



Аудитын тайлан

**Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын
санхүүгийн зарим үйл ажиллагаа**

**ДААТГАЛЫН САНГ ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАХ,
ӨСГӨН АРВИЖУУЛАХ БОДЛОГО ДУТАГДАЖ БАЙНА**

Улаанбаатар 2008 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгсийн жагсаалт	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
ҮАГ-ын Хоёрдугаар газар		
Газрын захирал Ц.Батбаяр	Бүлэг 1	
Аудитын менежер Х.Баярмаа	Үйл ажиллагааны зарим зардлыг хэтрүүлэн зарцуулжээ	
Ахлах аудитор С.Оюунгэрэл	Үйл ажиллагааны зардлын төсвийг үндэслэл муутай нэмэгдүүлсэн байна	4
Аудитор Ц.Цэрэнхүү	Шагнал урамшуулал, тэтгэмжийг хавтгайруулан олгожээ	6
Шинжээч Б.Болормаа	Хөрөнгө оруулалтын төсөвт хууль зөрчин зохицуулалт хийжээ	7
	УНДЕГ-ын удирдлага баталсан журмаа мөрдөөгүй байна	9
2008 оны 12 дугаар сар	Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг оновчтой сонгоогүй, захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна	11
	Бүлэг 2	
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү: www.mnao.pmis.gov.mn	Санхүүгийн эмх цэгц хангалтгүй байна	
	Сангийн хөрөнгийг үр ашиггүй байршуулжээ	13
	Дотоод хяналт үр нөлөө багатай байна	14
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263813 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.	Холбогдох байгууллагын санал	17
	Тайлбар	25
	Зөвлөмж	26
	Хавсралт 1	27
	Хавсралт 2	28
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс		

Товчилсон үгсийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ЭМДСЗ	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл
ГШЗ	Гомдлын шаардлагын зөвлөл
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс
НДС	Нийгмийн даатгалын сан
НДГ	Нийгмийн даатгалын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДА	Нийгмийн даатгалын алба
НД	Нийгмийн даатгал
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
СТӨ	Соёлын төв өргөө
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БУА	Барилга угсралтын ажил
БМСТ	Бүртгэл, мэдээлэл, сургалтын төв
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТБҮЦ	Түргэн борлогдох үнэт цаас
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны дарга болон УНДЕГ-ын даргын 2008 оны 7 дугаар сард ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

УНДЕГ-ын 2007 оны санхүүгийн нэгдсэн тайланд ҮАГ-аас хийсэн санхүүгийн аудитаар эрсдэл ихтэй байж болзошгүй хэмээн тогтоогдсон зардлыг нарийвчлан шалгаж, дүгнэлт гаргах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын 2007 он, 2008 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад баримтуудыг шалгав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад хамрагдах хугацааны санхүүгийн ажилтнууд ажлаас чөлөөлөгдсөнөөс асуудлыг тодруулах, тайлбар авахад хүндрэлтэй байв.

БҮЛЭГ 1

Үйл ажиллагааны зарим зардлыг хэтрүүлэн зарцуулжээ

1.1 Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн.*

1.2 Нийгмийн даатгалын байгууллага нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлж байгаа хуулийн этгээд юм.

1.3 Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар “Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллага нь тухайн шатны Засаг дарга болон нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлагын дор ажиллана” гэжээ.

1.4 Мөн хуулийн 27.1-д “УИХ нь Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн орон тооны бус гишүүдээс бүрдсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулна. Үндэсний зөвлөл ажлаа УИХ-д тайлагнана” гэж заасан байна.

1.5 УНДЕГ-ын даргаар 2007 оны 1 дүгээр улиралд М.Далайхүү, 2007 оны 4 дүгээр сараас 2008 оны 5 дугаар сарыг дуустал С.Эрдэнэ, нар ажиллаж байсан бөгөөд тухайн хугацаанд үйл ажиллагааны болон төв сангийн баримтад хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтныг томилж чөлөөлсөн 14 тушаал гарсан байлаа.

1.6 2008 оны 6 дугаар сараас УНДЕГ-ын даргаар Ч.Алтанхуяг, ерөнхий нягтлан бодогчоор 9 дүгээр сараас Д.Ууганбаяр нар ажиллаж байна.

Үйл ажиллагааны зардлын төсвийг үндэслэл муутай нэмэгдүүлсэн байна

1.7 Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын 2007 оны төсвийн төслийг урьд онуудын төсвийн болон тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл, төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадаас ирүүлсэн төсвийн санал, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн боловсруулж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу НДҮЗ-ийн 2007 оны 1 дүгээр тогтоолоор 4363.5 сая төгрөгөөр батлуулж мөрдсөн байна.

*УНДЕГ-ын веб хуудас

1.8 2007 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараахь үндэслэлээр 2 удаа нэмж тодотгон баталжээ. Үүнд:

НДҮЗ-ийн 2007 оны 16 дугаар тогтоолоор;

- Засгийн газрын 2007 оны 13 дугаар тогтоолын дагуу цалин, тэтгэврийг өөрчлөн нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх;
- НДҮЗ-ийн 2001 оны 5 дугаар тогтоолын дагуу барагдуулсан төлбөр, зөрчлийн 20 хувийг үйл ажиллагаанд зарцуулах;
- Нийгмийн даатгалын алба үүсч хөгжсөний 65 жилийн ойн арга хэмжээний зардлын хэмжээг тусгах;
- Ажилтнуудын хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;
- УНДЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Хамтын ажиллагааны газар, БНСУ дахь нийгмийн даатгалын алба байгуулахтай тус тус холбогдуулан 486.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

НДҮЗ-ийн 2007 оны 22 дугаар тогтоолоор;

- Засгийн газрын 2007 оны 237 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлсийг мөн оны 10 дугаар сарын 1-нээс нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн;
- Хяналт, мониторингийн алба байгуулагдсан зэрэг шалтгааны улмаас зардлын төсвийг 717.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт үйл ажиллагааны төсвийг 5567.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн тодотголоор хийгдсэн өөрчлөлтийг графикаар харуулбал:

(сая төгрөгөөр)



1.9 Төсвийн хоёр удаагийн тодотголоор УНДЕГ-ын үйл ажиллагааны зардлын төсвийг 408,5 сая төгрөгөөр буюу бараг 2 дахин өсгөсөн нь НДБ-ын үйл ажиллагааны зардлын төсвийн нэмэгдсэн дүнгийн 33.9 хувийг эзэлж байна.

1.10 НДБ-ын үйл ажиллагааны зардлын 2007 оны төсөвт УНДЕГ-ын зардлын эзлэх хувь оны эхэнд батлагдсан төлөвлөгөөгөөр 9.6 хувь байсан бол тодотгол хийснээр 14.9 хувь болж нэмэгджээ.

1.11 Үүнээс үзэхэд төв байгууллагын удирдлагын шийдвэр, ашиг сонирхолд нийцүүлэн ойн арга хэмжээ, шагнал урамшуулалд зарцуулах хөрөнгө буюу үр ашиггүй зардлыг нэмж төлөвлөснийг НДҮЗ баталгаажуулсан байна.

1.12 Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг УИХ-аас баталдаг болсон.

1.13 Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуулиар НДБ-ын 2008 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 8700.0 сая төгрөгөөр баталж, НДҮЗ-ийн 2007 оны 25 дугаар тогтоолоор УНДЕГ-ын урсгал зардлын төсвийг 1249.4 сая төгрөгөөр тогтоожээ.

1.14 НД-ын салбарын байцаагч, ажилтнуудыг төрийн захиргааны албан

хаагчийн ангилалд хамруулан цалингийн зардлыг төлөвлөсөн боловч төрийн үйлчилгээний ангиллаар цалинжуулснаар төсвийг 2007 онд 52.9 сая, 2008 оны эхний хагас жилийн байдлаар 43.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

1.15 НД-ын салбарын ажилтнуудын ангилал болон цалингийн сүлжээний энэхүү ялгаатай байдлыг арилгах шаардлагатай юм.

1.16 Хэдийгээр цалингийн төсвийг хэмнэсэн боловч байгууллагын дотоод журамд заасны дагуу 11 ажилтанд 1-3 сарын цалин, тэтгэмжтэй чөлөө олгож, тэдгээрээс 5 ажлын байранд түр хугацаагаар хүн авч цалинжуулсан нь төсвийг бодитой хэмнэх илүү боломж байсныг харуулж байна.

1.17 Цаашид төлөвлөлтийг төсвийн гүйцэтгэл, үнэ, инфляцийн өсөлт, бодит хэрэгцээ шаардлагатай уялдуулан үндэслэлтэй төлөвлөж, хянаж батлах нь зүйтэй байна.

Шагнал урамшуулал, тэтгэмжийг хавтгайруулан олгожээ

1.18 Нийгмийн даатгалын байгууллагуудын дүнгээр 2007 оны төсвийг 168.8 сая төгрөгөөр, үүний дотор эд хогшил худалдан авах зэрэг 7 нэрийн зардлыг 10.7-118.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн, бусад зардлыг 1.4-86.5 сая төгрөгөөр хэмнэжээ.

1.19 УНДЕГ 2007 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийг нийт дүнгээр 4.9 сая төгрөгөөр, зардлын нэр төрлөөр нь авч үзвэл 130.3 сая төгрөгөөр хэтрүүлснийг системийн байгууллагуудын төсвийн хэтрэлттэй харьцуулж үзэхэд 77.2 хувийг эзэлж байна.

УНДЕГ-ын үйл ажиллагааны зардлын хэтрэлтийг нэр төрлөөр нь үзүүлбэл:

(байгууллагын тайлангаар)

№	Үйл ажиллагааны зардлын төрөл	2007 он			2008 оны эхний хагас жил		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НДШ-ийн зардал				29 063,1	33 180,2	4 117,1
2	Бичиг хэрэг, аж ахуйн зардал				8 682,2	15 451,3	6 769,1
3	Тээвэр, шатахуун	16 039,7	24 788,9	8 749,2	8 420,9	18 359,4	9 938,5
4	Дотоод албан томилолт				40 000,0	44 980,0	4 980,0
5	Гадаад албан томилолт, арга хэмжээний зардал	55 500,0	74 010,0	18 510,0	34 000,0	66 193,5	32 193,5
6	Ном хэвлэл, маягт авах зардал				4 000,0	9 134,2	5 134,2
7	Реклам сурталчилгааны зардал				17 088,4	25 406,0	8 317,6
8	Эд хогшил авах зардал	8 400,0	32 301,8	23 901,8	3 334,1	32 211,1	28 877,0
9	Шагнал урамшуулал, тэтгэмжийн зардал	74 000,0	131 319,5	57 319,5	23 800,0	52 278,6	28 478,6
10	Аудит хийлгэх зардал	9 800,0	15 619,8	5 819,8			
11	Биеийн тамир, арга хэмжээний зардал				15 000,0	29 900,3	14 900,3
12	Солонгос дахь НДА-ны зардал	103 445,9	115 330,7	11 884,8			
13	Бусад зардал	20 000,0	24 157,6	4 157,6	10 860,4	18 100,7	7 240,3
	Зардлын хэтрэлт			130 342,7			123 703,2
	Бусад хэмнэгдсэн зардлын дүн			-125 377,5			-47 057,2
	Нийт зардлын хэтрэлт, хэмнэлт	827 049,7	832 014,9	4 965,2	504 143,2	580 789,2	76 646,0

1.20 Хүснэгтээс харахад аудитад хамрагдсан хугацаанд 5 нэр төрлийн зардлыг жил дараалан хэтрүүлснээс шагнал урамшуулал, тэтгэмжийн зардлыг 28.5-57.3 сая төгрөгөөр, гадаад албан томилолтын зардлыг 18.5-32.2 сая төгрөгөөр, эд хогшил авах зардлыг 23.9-28.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна. Тухайлбал, УНДЕГ-ын даргын:

- 2007 оны 398 дугаар тушаалаар Улс тунхагласны 83 жилийн ойг тохиолдуулан НДА-ны улсын анхдугаар зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан нэр бүхий 14 ажилтанд 4.3 сая төгрөг шагналд;
- 2007 оны 468 дугаар тушаалаар ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн НДХ, газрын дарга, менежер, ерөнхий нягтлан бодогч, байцаагч гэх мэт нэр бүхий 124 ажилтанд 15,9 сая төгрөг шагналд;
- 2007 оны 7 дугаар сард СТӨ-нд үзвэрийн билетийн үнэнд 2.2 сая төгрөг;
- 2008 оны 103 дугаар тушаалаар НДА үүсч хөгжсөний 66 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд 24.9 сая төгрөг, 107 дугаар тушаалаар уг ойн арга хэмжээний хүрээнд ажилтнуудын дунд зохион байгуулсан спортын арга хэмжээнд тэргүүн байр эзэлсэн нэр бүхий 23 ажилтны шагналд 3.3 сая төгрөг;
- 2008 оны 1 дүгээр сард байгуулсан БНСУ-д сурталчилгаа хийх гэрээгээр “Хурд” хамтлагт 5.7 сая төгрөг;
- 2006 оны санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрт Далай ван-аудит ХХК-д 9,8 сая, SM-аудит ХХК-д гэрээт ажлын хөлс 2,7 сая төгрөг тус тус зарцуулжээ.

1.21 УНДЕГ 2008 оны эхэнд ажиллаж байсан орон тооны ажилтнуудын 69.8 хувь буюу 60 гаруй хүнийг тухайн оны эхний хагас жилийн байдлаар, 2007 онд 30 орчим хүнийг тус тус гадаад томилолтоор явуулж, 154.5 сая төгрөг зарцуулсан нь тухайн зардлын хэтрэлтийн гол шалтгаан болжээ.

1.22 2007 онд ерөнхий газрын 2, орон нутгийн 34, 2008 онд ерөнхий газрын 26, орон нутгийн 33, нийт 95 хүнийг БНХАУ-д танилцах аяллаар явуулж 31.4 сая төгрөг зарцуулсан байна.

1.23 Түүнчлэн 2008 онд БНСУ-д “1000 дахь иргэний шимтгэл олгох баяр”-ын арга хэмжээнд 11 хүнийг оролцуулснаас гадна 2007-2008 онд хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч, сэтгүүлч 8 хүнийг байгууллагын зардлаар авч явжээ.

1.24 Албан томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас бичүүлж хянадаггүй, гадаад сургалт, арга хэмжээнд оролцуулснаар гарах үр дүнг тооцолгүй урсгалаар явж ирсэн байна.

1.25 Үүнээс харахад НД-ын төв байгууллага төсвийн хөрөнгөд үрэлгэн хандаж, удирдлагын үйл ажиллагаанаас шалтгаалах гадаад албан томилолт, арга хэмжээ, шагнал урамшуулал, тэтгэмжийн зардлыг их хэмжээгээр хэтрүүлэн зарцуулжээ.

1.26 Цаашид батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байх, шагнал, тэтгэмж, урамшууллыг хавтгайруулан олгох явдлыг таслан зогсоох, үр ашиггүй гадаад, дотоод томилолт, танилцах аялал, арга хэмжээний зардлыг багасгах шаардлагатай байна.


1.27 Өөрөөр хэлбэл даатгуулагчдын хөрөнгөнөөс өөрсдийн төсвийг их хэмжээгээр батлуулж аваад үрэлгэн зарах бус, аль болох арвилан хэмнэж, даатгуулагчдын эрх ашигт нийцүүлэн өсгөж арвижуулах нь зүйтэй юм.

Хөрөнгө оруулалтын төсөвт хууль зөрчин зохицуулалт хийжээ

1.28 Нийгмийн даатгалын байгууллагын хөрөнгө оруулалтын 2007 оны төсвийг

НДҮЗ-ийн 2007 оны 1 дүгээр тогтоолоор 1612.6 сая, 2008 оны төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуулиар 2665.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.

1.29 Хөрөнгө оруулалтын зардлын бүтцийн төлөвлөсөн хэмжээг графикаар харуулбал:



1.30 НДҮЗ 2007 онд хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан салбарын ажиллагсдын орон сууцны нөхцөлийг сайжруулахад зарцуулах 329.8 сая төгрөгийг УНДЕГ-т төвлөрүүлэхээр нэг удаа өөрчлөлт оруулсан бол УИХ-аар хөрөнгө оруулалтын зардлын зүйлээр нь баталсан 2008 оны төсвийг гурван удаа өөрчлөн тодотгосон байна.

Тодотголыг хүснэгтээр үзүүлбэл:

Зардлын төрөл	(сая төгрөгөөр)		
	НДС-ийн Төсвийн тухай хуулиар	НДҮЗ-ийн тогтоолоор	Өөрчлөлт
Албан конторын барилга	1 221,0	1 156,0	-65,0
Барилгын их засвар	186,9	198,4	11,5
Тавилга, эд хогшил	130,3	157,3	27,0
Компьютер, тоног төхөөрөмж	285,5	285,5	0,0
Ажилтны орон сууцны хөнгөлөлт	417,8	417,8	0,0
Автомашин худалдан авах	245,7	183,0	-62,7
Хөрөнгө оруулалтын бусад зардал	177,8	267,0	89,2
Дүн	2 665,0	2 665,0	0,0

1.31 Өөрчлөлт хийх болсон шалтгааныг тодруулбал:

- Хэлтсийн конторын барилга барих төсвийг Баянгол дүүргийн НДХ-т 300.0 сая, Завхан аймгийн НДХ-т 65.0 сая, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НД-ын тасагт 30.0 сая, Сэлэнгэ аймгийн НДХ-т 8.0 сая төгрөгөөр;
- Автомашин худалдан авах зардлыг Өвөрхангай аймгийн НДХ-т 4.0 сая, Завхан аймгийн НДХ-т 15.0 сая, УНДЕГ-т 28.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна

1.32 НДҮЗ-ийн 2008 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тогтоолоор дээрх тодотголыг Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн залруулжээ.

1.33 Хөрөнгө оруулалтын төсвийг батлахдаа интернет, сүлжээний засвар үйлчилгээ гэх мэт урсгал шинж чанартай зардлыг хамруулж байна. Тухайлбал, НДҮЗ-ийн 2007 оны 1 дүгээр тогтоолоор УНДЕГ-ын БМСТ-д компьютер, тоног

төхөөрөмж худалдан авах зардалд 106.2 сая төгрөг баталснаас 24.8 хувь буюу 26.3 сая төгрөгийг компьютер худалдан авахад, үлдэх 75.2 хувь буюу 79.9 сая төгрөгийг салбарын мэдээллийн бааз суурилуулах, интернет сүлжээний үйлчилгээ, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас хэвлэх, хүргүүлэх зардлыг санхүүжүүлэхээр тооцжээ.

1.34 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зардлын зүйл ангийг оновчтой тодорхойлж, үндэслэлтэй боловсруулах нь зүйтэй байна.

УНДЕГ-ын удирдлага баталсан журмаа мөрдөөгүй байна

1.35 2007 онд хөрөнгө оруулалтаар 1337.3 сая төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвтэй харьцуулахад 82.9 хувьтай байна.

Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Зардлын төрөл	(сая төгрөгөөр)		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт
Их засвар	41,4	66,6	25,2
Автомашин худалдан авах	63,0	69,1	6,1
Ажилтнуудын орон сууцны нөхцөл сайжруулах	329,8	343,8	14,0
Ажлын тусгай хувцас	87,9	90,4	2,5
Бүсийн сургалтын төвийн тоног төхөөрөмж	20,0	69,9	49,9
Компьютер тоног төхөөрөмж	261,7	270,4	8,7
НДХ-ийн конторын барилга	720,0	313,7	-406,3
Нийт дүн	1 612,6	1 337,3	275,3

1.36 Хүснэгтээс харахад хугацаандаа хийгдээгүй барилга угсралтын ажлын санхүүжилттэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын нийт төсвийг 275.3 сая төгрөгөөр хэмнэсэн боловч зарим нэр төрлийн зардлыг 2.5-49.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал, албан хэрэгцээнд автомашин худалдан авах төсвөөр:

- Баян-Өлгий аймгийн НДХ-т 10.0 сая төгрөг батлагдсан боловч Ланд Круизер-80 маркийн автомашиныг 21,0 сая төгрөгөөр худалдан авсан;
- УНДЕГ Хөвсгөл аймгийн НДХ-т батлагдсан 15.0 сая төгрөгийг тус хэлтсийн дансаар дамжуулан “Бүрдийн домог” ХХК-руу шилжүүлж, төлөвлөгөөнд тусгагдаагүй байхад Дундговь аймгийн НДХ-т автомашин авч өгсөн;
- ТӨХ-ны шийдвэргүйгээр УНДЕГ-ын даргын 2008 оны 13 дугаар тушаалаар УНДЕГ-т ашиглаж байсан 17.0 сая төгрөгийн Тоёота Ланд круизер автомашиныг Өмнөговь аймгийн НДХ-т, 18.4 сая төгрөгийн Тоёота Ланд Прадо маркийн автомашиныг Хөвсгөл аймгийн НДХ-т, 48.0 сая төгрөгийн Тоёота Ланд круизер 105 маркийн автомашиныг Орхон аймгийн НДХ-т тус тус шилжүүлсэн;
- УНДЕГ-ын даргын 2008 оны 5 дугаар тушаалаар Орхон аймгийн НДХ-ээс 16,5 сая төгрөгийн Тоёота Марк-2 маркийн суудлын автомашиныг УНДЕГ-т шилжүүлсэн (ТӨХ-ны тооллогоор Орхон НДХ биетээр байгаагаар тоолуулсан) боловч одоог хүртэл бүртгэлд тусгаагүй байна.

1.37 Түүнчлэн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2007 онд 329.8 сая, 2008 онд 417.8 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлэх зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсныг 2007 онд 14.0 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

1.38 УНДЕГ 2007-2008 онд НДҮЗ-ийн шийдвэргүйгээр ЭМД-ын сангаас 120.0 сая төгрөгийг үйл ажиллагааны дансанд төвлөрүүлэн батлагдсан төсөв дээр нэмж,

ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх, мөнгөн тэтгэлэг олгоход зарцуулж, хууль зөрчсөн байна.

1.39 УИХ-ын Байнгын хорооны тогтоолоор баталсан НДҮЗ-ийн дүрэмд зааснаар “НД-ын системд мөрдөх шагнал урамшууллын жишиг тогтоох, төрийн дээд шагналд тодорхойлох” эрхийг Үндэсний зөвлөлд олгожээ.

1.40 НДҮЗ-ийн 2001 оны 5 дугаар тогтоолоор хяналт, шалгалтын орлогын 20 хувийг НДБ-д зарцуулах түр журмыг баталж, үүний дагуу УНДЕГ-ын даргын 2001 оны 116 дугаар тушаалаар баталсан “НДБ, байцаагч, ажилтан, ажил олгогч нарт хяналт шалгалтын орлогоос шагнал, дэмжлэг тусламжаа үзүүлэх журам”-д “НДБ-д 3-аас доошгүй жил ажиллаж, улсын байцаагчийн эрх авсан ажилтанд орон сууц барих буюу худалдан авахад зориулан нэг удаа түүний үндсэн цалингийн 3 жилийн нийлбэрээс илүүгүй хэмжээний мөнгөн тусламж олгож болно” гэж заасан байна.

1.41 УНДЕГ-ын даргын 2007 оны 6 дугаар сарын 176 дугаар тушаалаар шинэчлэн баталсан журмын 2.1-д “НДБ-д 6 сар, түүнээс дээш хугацаагаар ажилласан ажилтнуудад урамшуулал, мөнгөн тэтгэлэг олгох”-оор заасан боловч шалгуурыг хангаагүй нэр бүхий 20 гаруй хүнд орон сууцны дэмжлэгт 104.2 сая төгрөг олгосныг түүвэрчлэн хүснэгтээр үзүүлбэл: /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү/

(мянган төгрөгөөр)

д/д	Дэмжлэг авсан хүний нэр	Эрхэлдэг ажил	Ажилд орсон огноо	Дэмжлэг олгосон огноо	Мөнгөн дүн	Тайлбар
1	А.Долгормаа	Б.Х.Эрхлэгч	07.05.03	07.08.31	6 600,0	Ажлаас гарсан
2	Ч.Дагвадорж	Газрын дарга	07.05.17	07.09.04	10 000,0	Ажлаас гарсан
3	Т.Нямцэцэг	Газрын орлогч дарга	07.08.15	07.10.11	3 000,0	Давхар олгосон, 2008.05.08-нд 3 сарын цалинтай чөлөө олгосон
				08.01.29	3 000,0	
4	Батзана Лхамсүрэн	Даргын туслах	07.05.02	07.08.31	6 600,0	
5	М.Энхзул	Даргын туслах	07.09.03	07.12.13	5 000,0	
6	Б.Энхжин	Даргын туслах	07.12.12	08.05.27	3 000,0	
7	Балжинням Лхамсүрэн	Мэргэжилтэн	07.12.14	08.01.29	2 000,0	Ажлаас гарсан
8	С.Гантөмөр	Албаны дарга	07.10.09	08.01.29	6 000,0	Ажлаас гарсан
9	Б.Эрдэнэбат	ЧД НДХ-ийн Менежер	07.07.04	08.01.29	6 000,0	Ажлаас гарсан
10	Г.Ууганхүү	МТСТ-ийн мэргэжилтэн	07.07.27	08.01.29	6 000,0	Ажлаас гарсан
11	Б.Нямсүрэн	БГД НДХ-ийн тасгийн дарга	07.10.20	08.01.29	6 000,0	Давхар олгосон
				08.05.20	2 000,0	
12	В.Уранчимэг	ХУД НДХ-ийн тасгийн дарга	07.08.15	08.01.30	2 000,0	Давхар олгосон
				08.05.27	2 000,0	

1.42 Хүснэгтээс харахад УНДЕГ-ын дарга асан С.Эрдэнэ туслахаараа 4 сар ажилласан хүнд 3.0-6.6 сая төгрөгийн дэмжлэг олгоод өөр ажилд шилжүүлж, нэг жилийн хугацаанд 3 хүнийг сэлгэн ажиллуулсан байна.

1.43 Ажилтны өргөдөл, хүсэлтийг харгалзахгүйгээр мэргэжлийн ур чадвар, ажлын үр дүн, тогтвор суурьшил зэрэг шалгуурыг хангасан эсэх талаар анхан шатны нэгжээр хэлэлцүүлэлгүй, шийдвэрийг удирдлагын хүрээнд гаргаж

байгаагаас тус байгууллагад 5 хүртэл сарын хугацаатай ажиллаж байгаа хүмүүст дэмжлэг олгож, баталсан журмаа зөрчжээ.

1.44 Үүнээс гадна дээд шатны байгууллагынхаа эрх бүхий зарим албан тушаалтныг ч дэмжлэгт хамруулан 2006-2008 онд нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөс 46.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал,

(мянган төгрөгөөр)

д/д	Дэмжлэг авсан хүний нэр	Ажилладаг байгууллага	Он	Мөнгөн дүн	Тайлбар
1	Л.Мөнхзул	НХХЯ-ны ахлах мэргэжилтэн	2006	17 250.0	
2	Д.Ганчимэг	ЗГХЭГ-ын НХХ-ийн асуудал хариуцсан референт	2006	6 000.0	Давхар олгосон
			2007	6 600.0	
3	Ц.Нацагдолгор	НХХЯ-ны газрын дарга	2007	6 600.0	
4	Г.Ганболд	НХХЯ-ны газрын дарга	2008	10 000.0	
	Дүн			46 450.0	

1.45 НД-ын байгууллагаас орон сууцны дэмжлэг авсан ажилтнуудын судалгаа, мэдээллийн сан бүрдүүлж ашиглахгүй, амьдралын нөхцөл, ажлын үр дүнг харгалзахгүй зарим ажилтанд хэд хэдэн удаа дэмжлэг олгожээ. Тухайлбал, Үйл ажиллагааны нягтлан бодогч Н.Отгонбаяраар өмнөх орон сууцны үнийн дутуу 9.3 сая төгрөгийг төлүүлээгүйгээр барахгүй, 2004 онд 2 өрөө байр олгож, 60 хувь буюу 11.2 сая төгрөгийг байгууллагаас төлсөн, 2008 онд 2.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэлэг өгсөн зэргээр 19 хүнд орон сууцны дэмжлэгийг 3 хүртэл удаа давхардуулан олгосон байна. /Хавсралт №2/

Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг оновчтой сонгоогүй, захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна

1.46 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь тодорхой бус, үр ашиггүй барилга байгууламж, их засварын ажил, төсөл, арга хэмжээг нэмж тусгасан, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг буруу гаргасан, ажлын гүйцэтгэл гараагүй байхад санхүүжүүлсэн, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг сольсон, хөрөнгийг тайлан балансад тусгаагүй, ажлын гүйцэтгэлд гэрээний дагуу зохих хяналт тавиагүй, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь тайлагнаагүй зэрэг зөрчил, дутагдал гаргасан байна.



1.47 2007 онд хөрөнгө оруулалт, их засвар, барилга байгууламжийн 23 хувь буюу 322.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 77 хувь буюу 1052.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулжээ.

1.48 Тухайн жилд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын арга хэмжээ ондоо бүрэн хэрэгжээгүй, барилгыг хүлээж авах гүйцэтгэл болон дүгнэлт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон тохиолдол нилээд байна.

Гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй төсөл, арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

(2008 оны 10 дугаар сарын байдлаар)

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая төг)	Гүйцэтгэгчид олгосон (сая төг)	Хугацаа	
			Эхлэх	Дуусах
Завхан аймгийн НДХ-ийн конторын БУА	220,0	93,0	2007.09.10	2007.11.20
Баянгол дүүргийн НДХ-ийн конторын өргөтгөлийн БУА	415,0	383,5	2008.02.25	2008.08.22
Дорноговь аймгийн НДХ-ийн конторын БУА	136,0	136,0	2008.04.14	2008.06.30
Ховд аймгийн НДХ-ийн конторын БУА	200,0	199,7	2008.06.02	2008.09.27

1.49 УНДЕГ Баянгол дүүргийн НДХ-ийн конторын өргөтгөлийн БУА-ын тендерийг шалгаруулахдаа холбогдох хуулийн дагуу тендерт оролцогчийн санхүү, техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх нотолгоогүйгээр гүйцэтгэгч “Баасан трейд” ХХК-ийг сонгож, 415.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээ байгуулжээ.

1.50 Өөрөөр хэлбэл “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийг үндэслэн Барилга, хот байгуулалтын яамнаас олгож буй “Бетон, төмөр бетон барилгын ажил үйлчилгээ эрхлэх” зөвшөөрөлгүй тус компанид эрх олгогдоогүй ажил үйлчилгээ явуулах боломжийг олгосноор барахгүй гэрээнд заагдсан ажлууд хийгдээгүй, явцын гүйцэтгэл гаргаагүй байхад УНДЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Эрдэнийн цохолт, зөвшөөрлөөр гэрээний үнийн 89 хувь буюу 368.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ.

1.51 Үүнээс гадна УНДЕГ-ын даргын тушаал, шийдвэрээр НД-ын төв, орон нутгийн байгууллагуудын хооронд үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг их хэмжээгээр хийж, шийдвэрийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлдэггүйгээс хөрөнгийг орлогод авч, бүртгэлд тусгахгүй байх, хөрөнгө үрэгдэх зөрчил гарч байна. Тухайлбал,

- УНДЕГ-ын дарга 2007-2008 онд автомашин, тээврийн хэрэгслийг системийн байгууллагын хооронд шилжүүлэх тухай 21 удаа тушаал гаргасан;
- Өвөрхангай аймгийн НДХ АХБ-ны “Нийгмийн хамгааллын салбарын хөгжил” төслөөр авсан 26 нэрийн 31,935 ам.долларын тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг тайлан тэнцэлд тусгаагүй;
- Булган аймгийн НДХ 2001 онд дуудлага худалдаагаар зарагдаж, 2006 онд иргэн Б.Баттөгсөөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан УАЗ-469 автомашины үнийг авлагаар тусгасан боловч үндсэн хөрөнгийн данснаас хасаагүй, тавилга эд хогшлын дансны оны эхний үлдэгдлийг 199.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Бүлэг 2

Санхүүгийн эмх цэгц хангалтгүй байна

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашиггүй байршуулжээ

2.1 Нийгмийн даатгалын тухай хуулиар “Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү” нь нийгмийн даатгалын сангийн орлогын нэг эх үүсвэр байхаар заажээ.

2.2 УНДЕГ-ын удирдлага нийгмийн даатгалын төв сангийн чөлөөт үлдэгдлийг мөнгөн хадгаламжийн хэлбэрээр байршуулах талаар 2007 онд арилжааны 7 банкт 18, 2008 оны эхний хагас жилд арилжааны 6 банкт 12 гэрээ байгуулан ажилласан байна.

2.3 2008 оны 2 дугаар улирлын тайлангаарх сангийн мөнгөн хадгаламжийн байршлыг товчлон харуулбал:

Д/д	Гэрээ байгуулсан арилжааны банкны нэр	Гэрээний хугацаа	Хадгаламжийн хүү (жилээр)	Гэрээний дүн	Байршуулсан мөнгөн хадгаламж
1	Улаанбаатар хотын банк	3 жил	4,8	8 200,0	9 200,0
2	Капитал банк	3 жил	4,8	15 000,0	14 000,0
3	Капитрон банк	2 жил	4,8	8 000,0	6 000,0
4	Монгол шуудан	2 жил	6,0	7 200,0	3 100,0
5	Зоос банк	1 жил	4,8	3 700,0	1 000,0
6	Зоос банк-106	1 жил	4,8	2 000,0	2 000,0
7	Анод банк	2 жил	4,8	2 000,0	2 000,0
8	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2 жил	6,0	3 000,0	3 000,0
	Дүн			49 100,0	40 300,0

2.4 Хүснэгтээс харахад хадгаламжийн 50.8 хувийг арилжааны 2 банкинд жилийн 4.8 хувийн хүүтэйгээр, 3 жилийн хугацаатай байршуулсан нь даатгуулагчдын мөнгөн хөрөнгийн эрсдэлийн удирдлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Анод банкинд байршиж буй 2.0 тэрбум төгрөгийн хадгаламж өнөөгийн байдлаар эрсдэлд оржээ.

2.5 Монголбанкнаас сар бүр гаргадаг статистик мэдээллийг авч үзвэл 2007 онд арилжааны банкуудын төгрөгийн 1 жил хүртэл хугацаатай хадгаламжийн жилийн хүүгийн түвшин 7.56-19.3 хувь байсан байна.

2.6 Энэхүү мэдээллээр 2008 оны эхний 5 сард Капитал банкны хугацаатай хадгаламжийн жилийн хүү тогтмол 14.4-18.5 хувь байжээ.

2.7 Гэтэл 2008 оны 1-5 дугаар сард Капитал банкт 10.0 тэрбум төгрөгийг жилийн 4.8 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай хадгалуулахаар 02, 28, 46, 53 дугаар бүхий дөрвөн гэрээг УНДЕГ-ыг төлөөлөн дарга С.Эрдэнэ, Төв сан хариуцсан ерөнхий ня-бо Д.Билэгсайхан нар байгуулсан байна.



2.8 Ийнхүү УНДЕГ-ын дарга асан С.Эрдэнэ, санхүүгийн албаны удирдлага Д.Баярсайхан, Д.Далхжав, Н.Отгонбаяр, Д.Билэгсайхан нарын албан тушаалтнууд “ТБҮЦ-ны хүү”, “Банк хоорондын захын хүү”, “Мөнгөний бодлогын хүү”-гийн түвшингээс доогуур хүүтэйгээр нийт 49.1 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийн гэрээг 1-3 жилийн хугацаатай байгуулж, 40.3 тэрбум төгрөгийг байршуулжээ.

2.9 Хариуцлага тооцох механизм, хууль эрх зүйн акт байхгүйг ашиглаж, УНДЕГ-ын дарга, санхүүгийн удирдлага Төв банкны мэдээллийг харгалзалгүй, арилжааны банкны сонирхолд нийцүүлэн мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулснаар даатгуулагчдын хөрөнгийг өсгөх боломжийг бүрэн ашиглаагүй байна.

2.10 Банкуудтай байгуулсан гэрээний бусад нөхцөл жигд бус байна. Тухайлбал, гэрээт хугацаанд зарлагын гүйлгээ хийвэл Монгол шуудан, Зоос банк хүүг жилийн 2.4 хувь, бусад банк жилийн 0.1-0.2 хувиар тооцох буюу бараг хүүгүй гэж болохоор нөхцөл тусгажээ.

2.11 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулах, өсгөх талаар удирдлагын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан эрх зүйн акт байхгүй нь дээрх байдалд хүргэжээ.

2.12 Нийгмийн даатгалын тухай хуульд 2008 оны 5 дугаар сард орсон нэмэлт өөрчлөлтөөр “Хуримтлалын сан”-гийн асуудлыг тусгасан боловч эрх бүхий байгууллагууд өнөөг хүртэл холбогдох журам, зааврыг боловсруулж гаргаагүй байна.

2.13 Сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу арилжааны банкинд хүүтэй байршуулахаас гадна Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авч, хүүгээр нь өсгөх зэргээр эрсдэлгүйгээр арвижуулах шаардлагатай байна.

Дотоод хяналт үр нөлөө багатай байна

2.14 НД-ын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих болон бусад эрхийг НДҮЗ хэрэгжүүлэхээр тусгажээ.

2.15 НДҮЗ нь орон тооны нарийн бичгийн даргатай, орон тооны бус 9 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг.

2.16 УНДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, санхүүгийн газрын бүтцэд Хяналт мониторингийн алба, Нийслэлийн НДГ болон аймаг дүүргийн НДХ-т орон тооны хяналтын байцаагч ажиллаж, дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

2.17 Дотоодын хяналт шалгалтаар 2007 онд 2761.1 сая төгрөгийн, 2008 оны эхний хагас жилд 1026.7 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлэн, нийт 3801.4 сая төгрөгийг барагдуулсан байна.

2.18 УНДЕГ-ын санхүүгийн ажилтан Архивын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин 2000 оноос хойшхи бүх санхүүгийн баримтыг байгууллагын архивт шилжүүлэлгүй өрөөндөө хадгалж байсныг архивт хүлээн авах 11 хүний

бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг УНДЕГ-ын даргын 2007 оны 171 дүгээр тушаалаар томилж, нийгмийн даатгалын Төв сангийн 2000-2007 оны 5 дугаар сарын баримтад дотоодын хяналт шалгалт хийсэн байна.

2.19 Шалгалтаар арилжааны банкинд байршиж буй хөрөнгийн үлдэгдлийг дараа онд шилжүүлэн тайлан балансад тусгаагүй, Зоос, Улаанбаатар банкинд байршуулсан сангийн мөнгөн хөрөнгөнд гэрээний дагуу хүү тооцуулаагүй, балансаас гадуур сангийн мөнгөн хөрөнгийг бүртгэсэн, баримтын бүрдэл дутуу, авлагыг барагдуулаагүй зэрэг 567 063 513 төгрөгийн зөрчил илэрчээ.

2.20 Тухайн шалгалтаар илэрсэн болон бусад зөрчилтэй асуудлыг хөндлөнгийн хяналтын байгууллагаар нягтлан шалгуулахаар 2007 оны 7 дугаар сард УНДЕГ-аас SM-Аудит ХХК-тай гэрээ байгуулан сангийн дээрх хугацааны баримтад аудит хийлгүүлжээ.

2.21 Аудитаар 2 159 318 024 төгрөгийн зөрчлийг холбогдох албан тушаалтан, байгууллагаар төлүүлэхээр санал гаргасныг нийгмийн даатгалын Улсын ерөнхий байцаагчийн 2007.10.04-ний 02 дугаар актаар баталгаажуулсан байна.

2.22 2007 оны 11 дүгээр сард УМХГ-аас УНДЕГ-ын төв сан болон үйл ажиллагааны зардлын 2006 оны санхүүгийн баримтад шалгалт хийж тайлагнасан байна.

2.23 2008 оны 3 дугаар сард YAГ-аас тус байгууллагын 2007 оны санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж, хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.

2.24 Дотоодын болон хөндлөнгийн хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр, зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, хугацаатай үүрэг өгч байсан боловч биелэлтийг гаргаж тайлагнаагүй, зөрчлийг бүрэн арилгах талаар санаачлагатай ажиллаагүйгээс тодорхой үр дүн гараагүй, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил давтагдан гарсаар байна. Тухайлбал:

- Үнэт цаас, маягтын дансыг НДС-гийн болон үйл ажиллагааны төсвийн санхүүгийн тайланд тусгахгүйгээр тусад нь тайлан гаргаж байгааг YAГ-аас 2006, 2007 онд хийсэн аудитаар нэгтгэх тухай зөвлөмж өгсөн боловч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй;
- 2008 оны эхний 5 сарын байдлаар үнэт цаас, маягтын данснаас 323.4 сая төгрөгөөр НДС-ын хуулийн холбогдолтой гэх их хэмжээний сурталчилгааны материал хэвлүүлэн орон нутагт тарааж, төлөвлөгдөөгүй зардал гаргасан;
- Санхүүгийн тайланд хавсралт тодруулгыг НББОУС-ын дагуу бэлтгээгүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ямар банкны харилцах дансанд хэдэн төгрөгийн үлдэгдэл байгаа талаарх жагсаалт, авлага, өглөгийн дэлгэрэнгүй түүхийг заавар аргачлалын дагуу бэлтгэн толилуулаагүй;
- НДС-ийн төсвийн зарлагаар баталсны дагуу YOMШӨ-ий даатгалын сангаас хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар сургалт, сурталчилгаа зохион байгуулахад зориулж, MAOЭНХ-д 2007 онд 40.2 сая, 2008 онд 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч гүйцэтгэлийг НДҮЗ-д ирүүлж хянуулаагүй, гэрээнд заасны дагуу улирал тутам дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрнээр нь олгосон;
- Нийгмийн даатгалын төв сангийн тайлангийн авлагын 2007 оны эцэс, 2008 оны эхний үлдэгдлийг програмд зөрүүтэй тусгасан;
- Төв сангийн ХХБ дахь 2149003 данснаас 2000 оны 11 дүгээр сарын 17-нд "Алтжин" ХХК-ний тус банкинд дахь 2103641 дансанд шилжүүлсэн 220.0 сая төгрөгийн баримтыг үндэслэн тооцогдох хүүгийн хамт тус компаний нэрээр авлагад тусгах тухай хяналтын байгууллагын дүгнэлтийг хэрэгсээгүй байна.

2.25 Кассын зарлагын баримтад дарга, нягтлан бодогчийн зөвшөөрөлгүйгээр зөвхөн няравын гарын үсгээр зарлага гаргаж байгаа нь НД-ын төв байгууллагын санхүүгийн дотоод хяналт ямар байгааг харуулж байна.

2.26 УНДЕГ нь НББ-ийн бодлогын баримт бичгийг Сангийн ямаар хянуулж батлуулаагүй, зөвшөөрөлгүй програм хангамж ашигладаг, үйл ажиллагааны бүртгэлийн програм хангамж шаардлага хангахгүй, санхүүгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахгүй байна.

2.27 Аудитаар орон сууцны дэмжлэгийг давхардуулан олгосон, ЭМДС-аас ихээхэн хэмжээний хөрөнгийг үйл ажиллагааны зардалд татан төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулсан, эд хөрөнгийн тооллогыг биечлэн тоолоогүйгээс хөрөнгө бусдад ашиглуулсан, тооллогын зөрүүг одоо болтол шийдвэрлээгүй, удирдлагын шат дамжлага, орон тоо ихэссэн хэрээр зардал нэмэгдэж, боловсон хүчний бодлого, тогтвор суурьшил алдагдаж, мэргэжилтэй болон мэргэшсэн хүмүүс цөөрсний зэрэгцээ НДҮЗ төсвийн гүйцэтгэлд хяналт тавих үүргээ хангалтгүй хэрэгжүүлж ирсэн нь ажиглагдлаа.

2.28 Аудитаар 1100,9 сая төгрөгийн зөрчил илэрсэн болно.

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2008.12.31 № Н/502
тантай _____-ны № 1/398 -г

Хувиартай № 02

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн зөвлөмжинд тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах асуудлыг зохицуулах дүрэм, журам боловруулах чиглэлээр тус яамнаас холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжиж байна.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Д.Баттөр

Д.БАТТӨР

᠑᠔ 446᠑



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

210646 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32-80-30, Факс: 32-07-16,
E-mail: undeg@ndaatgal.mn
http://www.ndaatgal.mn

2008.12.29 № 1/2550

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тусгайлан өгөх саналгүй болно.

Цаашид аудитын тайлангийн хүрээнд өгсөн зөвлөмжийг баримталж ажиллах болно.



Ч.АЛТАНХУЯГ

1003856



МОНГОЛ УЛС
МОНГОЛ БАНК

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 9, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2008.01.05 № 1/12
танай 2008.12.22 ны № 1/398 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

Монгол улсын Үндэсний Аудитын газраас Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж үзээд Монголбанкны зүгээс тусгах ямар нэгэн саналгүй болохыг үүгээр уламжилж байна.




Б.ЭНХХУЯГ

Alban9.doc



МОНГОЛ УЛСЫН
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХОДӨЛМӨРИЙН САЙД

210548 Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний тудамж 5,
утас: 26-15-53, факс: 32-85-34, E-mail: Mow@mongolnet.mn

УЛААНБААТАР № 412
ТАНАЙ 2008 ОНЫ № 4398 -Т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

Санал өгөх тухай

Танай 2008 оны 1/398 тоотой ирүүлсэн "Даатгалын санг үр ашигтай зарцуулах, өсгөн арвижуулах бодлого дутагдаж байна" УАГ-2/2008/02-ЭА Аудитын тайлантай танилцаад дараахь саналыг хүргүүлж байна.

1. Аудитын тайланд тусгагдсан НДЕГ-ын үйл ажиллагааны зарим зардлыг хэтрүүлсэн, төсвийг үрэлгэн хандлагаар төлөвлөн батлуулсан, шагнал урамшуулал, тэтгэмжийг хаатгайруулан олгосон, хөрөнгө оруулалт, барилга байгууламжийн санхүүжилтийг зохих хууль журмын дагуу нийлүүлээгүй зэрэг тусгасан асуудлуудтай танилцлаа. Цаашид санхүүгийн сахилга батыг чандлан сахиулах, холбогдох хууль, журамд зохицуулалтыг тодорхой болгох, санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах талаар бүх шатны арга хэмжээ авч ажиллах болно.

2. Аудитын тайлангийн төслийн 2.11-2.13-т тусгагдсан хэсгүүдийг хасах.

"Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах асуудлыг зохицуулах дүрэм журам боловсруулж мөрдүүлэх талаар";

2008 оны 5 дугаар сард батлагдсан "Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиар Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөөр хуримтлалын сан байгуулах, уг сангийн хөрөнгөөр Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Хуулийн дагуу хуримтлалын сангаас хөрөнгө оруулалтад оруулах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батлах бөгөөд арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтоохоор эрх зүйн орчинг бүрдүүлсэн болно.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулснаар сангийн зохистой менежментээр хангах, ирээдүйд олгох тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтийг бүрдүүлэх боломжтой ч энэ нь нөгөө талаар өндөр эрсдэлтэй, улс орны санхүүгийн зах зээлийн хөгжлөөс шууд хамаарсан бодлого юм. Тус яам нь 2006 оны 10 дугаар сард Азийн хөгжлийн банкинд албан хүсэлт гаргаж, тэтгэврийн

(Сүмбэйг Мү дик зэм бичвэ)

08 923

Тайлбар
1-ийг үзнэ
үү.

сангийн хөрөнгө оруулалтын зохистой орчинг хэрхэн бүрдүүлэх, урт хугацааны бодлогыг хэрхэн тодорхойлох талаар төсөл хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын зөвлөхүүдээс зөвлөмж авч ажилласан юм.

Уг төсөл 2007 оны 9 дүгээр сараас 2008 оны 5 дугаар сар хүртэл хэрэгжсэн бөгөөд дээрх асуудлын хүрээнд тодорхой зөвлөмжүүд гарсан.

Тухайлбал Монгол Улсын Засгийн газар ДНБ-ээс индексжүүлсэн бондын хөтөлбөр хэрэгжүүлэх тогтолцооны үйл ажиллагаанд чиглэсэн нөхцөлд зах зээл дээрх үнэт цаасанд хэсэгчилж буюу бүрэн хөрөнгө оруулалт хийх боломжтой удирдлагын бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх, нэрийн дансны тогтолцооны хөрөнгө оруулалтыг хамгаалах онцгой шаардлага байгааг дурьдсан. Бүтцийг бий болгоход наанадаж хөрөнгө оруулалтын удирдлагыг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, үйл ажиллагааг хянаж шалгахад чиглэсэн хууль хэрэгжүүлэх механизм бий болгох шаардлагатай бөгөөд эдгээр гурван үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Засгийн газрын бондын хөрөнгө оруулалтыг хянах боломж бүрдэнэ.

Улмаар жинхэнэ утгаараа хэрэгжих хөрөнгө оруулалтын менежмент хийх мэргэшсэн туршлага, зах зээлийн ойлголт, нөхцөл боломж Засгийн газрын ажилтнуудад ихэвчлэн дутагдаж байгаа бөгөөд төрөөс гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын тусгай мэргэжилтнүүдийг ажиллуулах эрх зүйн орчин, нөхцөл боломж бүрдээгүй байна. Иймд бид тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулалтаар туршлагажсан лиценз бүхий менежерүүдийг ажиллуулах, ажлыг хянаж, зохицуулах үр өгөөжтэй механизм бүрдүүлэхэд зэрэг илүү туршлагатай, үр өгөөжтэй ажиллах боломжийг эрэлхийлэх, механизмыг бүрдүүлэх бодлого баримталж байна.

Хүндэтгэсэн,



A handwritten signature in blue ink, appearing to read "T. Gandi".

Т.ГАНДИ

/Dyumbileg My doc tom bliniv



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-13/1, Утас/Факс: 976-11-327936

2008-12-24 № 31
Танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн
төсөлд санал өгөх тухай

"Даатгалын санг үр ашигтай зарцуулах, өсгөн арвижуулах бодлого дутагдаж байна" Аудитын тайлантай танилцаад дараахь саналыг хүргүүлж байна.

"Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах асуудлыг зохицуулах дүрэм журам боловсруулж мөрдүүлэх талаар";

2008 оны 5 дугаар сард батлагдсан "Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиар Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөөр хуримтлалын санг байгуулах, хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн болно.

Улмаар хуримтлалтын сангаас хөрөнгө оруулалтад оруулах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батлах бөгөөд арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтоохоор хуульчилсан, 1995 оноос хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд сангийн хөрөнгөөр эрсдлийн болон хуримтлалын тусгай санг бий болгох ямарваа нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй байсан бөгөөд дээр дурьдсан хуулийн өөрчлөлтөөр "хуримтлалын сан" байх эрх зүйн орчин бүрдсэн нь тодорхой нэг ахицтай алхам болсон. Гэвч уг сангийн үйл ажиллагааг тэтгэврийн урт хугацааны стратегитай уялдуулах нэмэлт зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах нь даатгуулагчдийн төлсөн шимтгэл хөрөнгийг зохистой менежментээр хангаж ирээдүйн тэтгэвэр, тэтгэмжийн зорилтыг хангах үндсэн агуулгатай. Хэдийгээр сангийн хөрөнгийг арвижуулах, үнэгүйдэлд оруулахгүй байх нь зохистой ч энэ нь

нөгөө талаар өндөр эрсдэлтэй, улс орны нийгэм, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын зах зээлийн хөгжилтэй шууд холбоотой байгаа юм.

Иймд бид цаашид нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлыг хянаж, зохицуулах үр өгөөжтэй механизм бүрдүүлэхэд илүү туршлагатай, үр өгөөжтэй ажиллах боломжыг эрэлхийлж, бодлого баримталж байна.

2008 оны 8 дугаар сард Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад байршуулсан байдлын тухай Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд танилцуулах үүргийг УНДЕГ-т өгч улмаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад мөнгөн хадгаламжийг байршуулахад Монгол банкнаас гаргасан арилжааны банкуудын төлбөрийн чадамжийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүд, хөрөнгийн чадварт нийцүүлсэн байх, мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгаламж байршуулах үеийн Төв банк, Засгийн газрын үнэт цаасны хүүгээс доошгүйгээр, санхүүгийн зах зээлийн дундаж хүүтэй уядуулан байршуулах, Улаанбаатар, Капитал банкны хөрөнгийн чадварын үзүүлэлтээс илүү байршуулсан мөнгөн хадгаламжийг буцаан татах ажлуудыг шуурхай хэрэгжүүлэх талаар УНДЕГ азарт үүрэг болгосон.

Түүнчлэн Сангийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нар Төрийн сан, арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршиж буй хөрөнгийн хадгаламжийн хүүгийн хэмжээ зах зээлийн хүүгээс харьцангуй доогуур, журам, дүрэм арга механизм тодорхой бус байгаа талаар шүүмжлэлтэй хандаж сангийн хөрөнгийг байршуулах, үр ашигтай ашиглах, хяналтыг сайжруулах талаар журам, дүрэм боловсруулах зөвлөмж өгсөн.

Дээр дурьдсан асуудлаар ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамтай хамтран Нийгмийн даатгалын сангаас арилжааны банкуудад байршиж байгаа хөрөнгийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дээрх сангуудын чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулах эрх зүйн харилцааг боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэж байна. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монгол Банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох гишүүд оролцоно.

НДҮЗөвлөл нь нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамтай хамтран Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. УИХ-ын 2008 он 5 дугаар сарын 8-ны өдрийн нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнө Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогоос санхүүжиж байгаа нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталж гүйцэтгэлд нь хяналт тавьдаг тогтолцоо үйлчилж байсан юм. Дээрх хуулийн өөрчлөлтөөр Нийгмийн даатгалын санг Улсын төсвөөс тусгаарлан сангийн жил бүрийн орлого зарлагыг

төсвийг УИХ батлан төсвийн гүйцэтгэлд нь хяналт тавин тус сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийн баталгаажуулах тухай харилцааг зохицуулсан бөгөөд цаашид уг хуулийн мөрдөн ажиллах болно.

Мөн нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэх нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар тогтоохоор заасан бөгөөд харин Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавихаар хуульчлагдсан. Энэхүү хуулийн хүрээнд 2008 оны хөрөнгө оруулалтын нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэн баталж байгаа болно.

Нийгмийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэлийн хяналтыг чангатгах үүднээс санхүүгийн ажилтнуудыг мэргэшүүлэх, дадлага туршлагатай ажилтнуудыг бэлтгэх, сэлгэн ажиллуулах талаар анхааран ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Цаашид танай газрын зөвлөмжийн дагуу Даатгалын санг үр ашигтай зарцуулах, өсгөн арвижуулах бодлогыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллах болно.

Хүндэтгэсэн,



S. Chinzorig С.ЧИНЗОРИГ

ҮАГ-ын тайлбар 1:

Аудитад хамрагдсан буюу 2008 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулах, өсгөх талаар удирдлагын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан дүрэм, журам байгаагүйгээс тайланд дурдсан зөрчил гарсан байна.

УИХ-аас 2008 оны 5 дугаар сард баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар дээрх асуудалтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлсэн тухай аудитын тайланд тусгасан.

Гэвч хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах, бонд, үнэт цаас худалдан авч, өсгөн арвижуулах талаарх гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байгааг үндэслэн дүрэм журам боловсруулж мөрдүүлэх тухай өгсөн зөвлөмжийг Монголбанк, Сангийн яам, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл хүлээн авч хэрэгжүүлэхээр санал ирүүлсэн байна.

Иймд тус яамнаас өгсөн саналыг хүлээн авах боломжгүй байна гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Монголбанкны ерөнхийлөгч А.Батсүх, Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, НДҮЗ-ийн дарга С.Чинзориг нарт:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах асуудлыг зохицуулах дүрэм журам боловсруулж мөрдүүлэх;

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид:

- УНДЕГ-ын даргатай байгуулах үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, хариуцлагыг сайжруулах;

НДҮЗ-ийн дарга С.Чинзоригт:

- Нийгмийн даатгалын төв байгууллагын орон тоо, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тодорхойлон удирдлагын шат дамжлагыг багасгах арга хэмжээ авах;
- Нийгмийн даатгалын сангаас зарцуулах үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж батлуулах, төсвийн гүйцэтгэлийн нэр төрлөөр хийх хяналтыг тогтмолжуулах;
- Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэлийг гаргаж тайлагнах;

УНДЕГ-ын дарга Ч.Алтанхуягт:

- НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, Төв сангийн болон үйл ажиллагааны бүртгэлийн програм хангамжийг сайжруулах;
- Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, цаашид давтан гаргуулахгүй байх, хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн боловч гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй, дуусаагүй барилга байгууламжийн ажлын гэрээг дүгнэж, биелэлтийг хангуулах;
- Арилжааны банкуудтай байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээг зах зээлийн түвшинд нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
- Дотоодын болон хөндлөнгийн хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, маягт, үнэт цаасны болон бусад орлогыг нэгтгэсэн тайланд тусгах;
- Орон сууцны дэмжлэгт хамрагдагсдын судалгаа, мэдээллийн сантай болж, хэт хавтгайруулж, давхардуулан олгохыг зогсоох;
- НДШ-ийн өрөнд авсан барилга, объектын түрээсийн болон худалдах, худалдан авах гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, шаардлагатай гэж үзвэл зарим гэрээг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.